



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 09 өдөр

Дугаар А/453

Хэрлэн сум

Тэмцээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр хуралдааны “Аймгийн Засаг даргын 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагаа хөтөлбөрийн жагсаалт” 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор уламжлал болон зохион байгуулагддаг “Барилгын удирдах ажилтны зөвлөгөөн, мэргэжлийн ур чадварын тэмцээн” нэгдсэн арга хэмжээнд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, арга хэмжээг зохион байгуулах ажлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ